

Зүүн Хойд Азид дөрвөн талт (3+1) хамтын ажиллагаа өрнүүлэн хөгжүүлэх боломж арга зам

Проф. Ц.Баатар*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд стратегийн түншилэлийн нягт харилцаатай Монгол, Хятад, Орос улс бүс нутгийн бусад орнуудаас илүү БНАСАУ-тай уламжлалт найрсаг харилцаатай, харилцан бие биенээ ойлголцсон, итгэлцэл дээр суурилсан 2 талын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа өрнөн хөгжиж байгаа билээ. Энэ үүднээс авч үзвэл эхний шатанд дээрхи дөрвөн улсын бие биенээ нөхсөн, харилцан ашигтай хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх нь ихээхэн чухал ач холбогдолтой хүчин зүйлийн нэг болохыг нээн харуулах оролдлого хийсэн.

Түлхүүр үг: Зүүн хойд Ази, Монгол, ОХУ, БНХАУ, БНАСАУ, худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа.

Abstract: Mongolia, China, Russia continental states characterized of having traditional good relations with the DPRK. Consequently, they enjoy bilateral trade and economic cooperation. From this perspective, I think, as a first step, a mechanism, needs to set up among the four nations. This mechanism should be complementary and mutually beneficial. The main idea of my paper is precisely to develop this idea.

* * *

Даяаршлын өнөөгийн эринд улс орнуудын харилцан хамаарал улам бүр өсөн нэмэгдэхийн хэрээр глобал эдийн засагт нэгдэж, интеграцчлагдах үйл явц эрчимтэй өрнөх болов. Ялангуяа бүс нутгийн орнуудын бие биенээ нөхсөн, харилцан нөхцөлдсөн хамтын ажиллагаа

урьд өмнөхөөс илүү түргэн хурдацтай өрнөн хөгжиж байна. Үүний нэгэн тод жишээ бол бидний өнөөдрийн хуралдааны гол сэдэв болсон ЗХА-ийн бүс нутаг юм. Бүс нутгийн орнууд зөрчил маргаантай асуудлаа хойш тавьж энхийг эрхэмлэж, бүс нутгийн хэмжээнд тулгамдсан асуудлаа хамтран шийдвэрлэх, эдийн засгийн өсөлт хөгжил, уур амьсгалын өөрчлөлт зэрэг асуудалд түлхүү анхаарах болов.

Даяаршлын үр шимийг хүртэж, түүнд идэвхтэй оролцдог дэлхийн олон улс, тэдгээрийн сая сая иргэд хүссэн хүсээгүй өөр хоорондын өчнөөн олон хэлхээ холбоосоор холбогдож, хэн нэг нь хожиж ялах дийлэх тухай ойлголт байхгүй болчихсон тийм цаг үед бид бүхэн амьдарч байна. Эдийн засгийн солилцоо бол харилцан бие биенээ таньж мэдэх, ойлголцоход хувь нэмрээ оруулж байдаг. Учир нь тийм солилцоо нь хэрэг дээрээ геостратегийн хамтын сонирхол болон харилцан хамаарлыг дэмжин лавшруулж, ингэснээрээ аюулгүй байдлын салбарын сөргөлдөөн аль ч талд нь ашиггүй бөгөөд тэр чанараараа сөргөлдөх магадлал буурахад дэм үзүүлдэг. Эдийн засгийн ийм хэлхээ холбоо, харилцан хамаарлын тодорхой жишээ Монгол-Хятадын, Монгол-Оросын, Орос-Хятадын харилцааг ч энд хамааруулан авч үзэж болох юм. Учир нь эх газрын энэ гурван хөрш улс аль хэдийн эдийн засаг, санхүүгийн нягт харилцаатай болсоор байна.

Энд юуны өмнө гурван хөршийн БНАСАУ-тай тогтоосон худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар цухас өгүүлэхийг хичээе.

1. Монгол улс БНАСАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа

Хоёр орны эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын зөвлөлдөх комисс 1988 онд байгуулагдсан билээ. Зөвлөлдөх комиссын ээлжит хуралдаануудаар хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг өнөөгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан хөгжүүлэх асуудлаар санал солилцож, эдийн засгийн хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чиглэгдсэн гэрээ хэлэлцээр байгуулах, зарим пүүс компаниудын хооронд хамтран ажиллах, өөрсдийн орны эдийн засаг, санхүүгийн чадавхтай уялдуулан

бодитой хэрэгжүүлж болох тодорхой цөөн салбар, объект дээр тогтон ярилцаж, хэрэгжүүлэхэд нь хоёр улсын Засгийн газрын зүгээс дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2013 оны 10 дугаар сард БНАСАУ-д хийсэн албан ёсны айлчлал нь хоёр орны найрсаг харилцааг шинэ шатанд гаргаж чадсан айлчлал болсон билээ. Айлчлалын үр дүнд “Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т холбогдох талууд гарын үсэг зурж баталгаажуулсан явдал юм. Хэлэлцээрийн дагуу БНАСАУ-ын Сэпү тал нутагт мал аж ахуй хөгжүүлэхэд Монголын талаас дэмжлэг үзүүлэх бол Умард Солонгосын тал Монголын түүхий эдийн нөөцийг ашиглан хөнгөн үйлдвэрлэл хөгжүүлэх юм. Түүнчлэн хонины ноосоор даавуу үйлдвэрлэх, нүүрснээс мяндас гарган авах, Кэсон дахь аж үйлдвэрийн цогцолборт хувцас хэрэглэл, оёмол нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр урт хугацаанд хамтран ажиллах болж байна. Дээрхи хэлэлцээрийн хүрээнд үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар дахь хоёр орны давуу тал, нөөц бололцоог бүрэн ашиглах замаар харилцан ашигтай байх зарчимд тулгуурласан, эдийн засгийн үр өгөөжтэй, ажил хэрэгч хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн гэрээ хэлцлүүд байгуулагдлаа.

Ийнхүү хоёр орны дээд хэмжээний уулзалтууд тогтворжиж, улс төрийн харилцаанаас илүү прагматик, бие биенийн ашиг сонирхлыг харгалзсан эдийн засгийн харилцаа руу түргэн хурдтай шилжиж байна.

Монгол-Хойд Солонгосыг холбох бас нэг хүчин зүйл нь ажиллах хүч. Хичээл зүтгэлтэй ажилладаг, өндөр цалин хөлс нэхдэггүй чухам л “капиталист мөрөөдөл” болсон ажилчдыг Хойд Солонгосоос оруулж ирэх сонирхол бидэнд бий. Монгол улсад Хойд Солонгосын ажилчдыг хоёр орны засгийн газрын хэлэлцээрийн дагуу ажлын байрны төлбөрөөс чөлөөлөн оруулж ирснээр одоогийн байдлаар барилга, оёдлын үйлдвэр зэрэг аж ахуйн нэгжид 3000 орчим ажилчин ажиллаж байна. Энэ тоо цаашдаа ч өсөн нэмэгдэх чиг хандлагатай байна.

2013 оны 9 дүгээр сард болсон Монгол Улс, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын Зөвлөлдөх комиссын 9 дүгээр хуралдаанаар Худалдаа, эдийн засаг, хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааны өнөөгийн байдалд үнэлэлт өгч, цаашид эдгээр болон бусад салбарт хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцож, МҮХАҮТ, БНАСАУ-ын Гадаад худалдааны яам хоорондын хамтын ажиллагааны Санамж бичиг, Засгийн газар хоорондын 9 дүгээр хуралдааны Протоколыг баталгаажуулсан явдал хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг идэвхижүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Үүний нэгэн жишээ гэвэл энэ оны эхээр Улаанбаатар хотноо болсон Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын Азийн бүсийн гишүүн орнуудын “Транзит Монгол” зөвлөлгөөнөөр Оросын нутгаар дамжуулан Хойд Солонгосын “Радеон” боомт руу 20 мянган тонн нүүрс гаргахаар тохиролцоонд хүрлээ. Хоёр улсын бизнесийн салбарт ч ахиц өөрчлөлт гарч байна. Тухайлбал, Монголын “НВ Oil” компани Хойд Солонгосын нефть боловсруулах төрийн өмчит компанийн 20 хувийн хувьцааг худалдан авсан нь хувийн хэвшлийн хамтын ажиллагааны нэгээхэн жишээ. Тус компани Хойд Солонгосын Сунгри үйлдвэрт түүхий нефть нийлүүлээд, эргээд боловсруулсан түлшээ Монголдоо экспортлох юм¹.

Хойд Солонгост манай бизнесменүүд хамтарсан компани байгуулсан тухай болон хоёр орны хамтын ажиллагааны талаар Хойд Солонгосын “Rodong Sinmun”, “Чусонг Илбу” зэрэг төв хэвлэлд нь мэдээ материал тогтмол нийтлэгдэх болсон нь хоёр улсын харилцаа хамтын ажиллагаа амжилттай өрнөн хөгжиж байгаагийн нэгэн илэрхийлэл гэж үзэж болох байна. Өнгөрсөн 5 дугаар сарын эхээр манай улсад Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос ард улсын Эдийн засгийн хөгжлийн хороо, Төмөр замын яамны төлөөлөгчид ажлын айлчлал хийж, айлчлалын хүрээнд төмөр зам, хөрөнгө оруулалт, эдийн засгийн чөлөөт бүсийн талаар голлон хэлэлцлээ.

Хоёр улс сүүлийн жилүүдэд барилга байгууламж, дэд бүтцийн салбар, Дорнод бүсийн хөдөө аж ахуй, мал аж ахуй салбарт хамтран ажиллах, хоёр орны хооронд бартерийн худалдаа, аялал жуулчлалыг хөгжүүлэх, соёл, хүмүүнлэгийн чиглэлээр идэвхитэй хамтран ажиллаж байна.

1. <http://www.assa.mn/content/17981.shtml>

Метал, газрын ховор элементээр баян Хойд Солонгосын хувьд уул уурхайдаа түшиглэн эдийн засгаа хөгжүүлэх Монголын загвар хэрэгтэй байх тал бийг ч үгүйсгэх аргагүй.

Дүгнэж хэлэхэд Монгол-Хойд Солонгос газар нутгийн хувьд ойр, нэг бүс нутагт оршдог, хоёул хөрш их гүрэн-Хятад, ОХУ-тай хиллэдэг, хөгжлийн бэрхшээл адилаатар, ирээдүйд бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны интеграцид оролцон хөгжихгүйгээр аль алин нь мухардана гэхчлэн нийтлэг тал бий. Манай улс цаашид Солонгосын хойгоор дамжин далайд гарах хамгийн дөт зам нээгдэх, Солонгос хоорондын төмөр болон авто зам сэргэн, улмаар томоохон мега төслүүд болох Ази-Европыг холбосон авто болон төмөр зам, байгалын хий, газрын тосны хоолойн сүлжээнд холбогдох болон энэ бүсэд эхлэл нь тавигдсан “Их Түмэн санаачлага” төсөл зэрэг бодит хүчин зүйлүүд нь манай улсын хувьд БНАСАУ-тай сайн харилцаатай байж, хамтын ажиллагааг хөгжүүлэх явдлыг нөхцөлдүүлж байна.

2. БНХАУ, БНАСАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа

Уламжлалт найрсаг харилцаатай хоёр улсын худалдаа эдийн засгийн харилцаа жил ирэх бүр өсөн нэмэгдэж, улам бүр харилцан хамааралтай болж Умардын гадаад худалдааны дийлэнхи хувь нь Хятадад ногдож байна.

2013 оны байдлаар хоёр орны худалдааны эргэлт 6.5 тэрбум ам. долларт хүрч, Хойд Солонгосоос Хятадад экспортлосон бараа бүтээгдэхүүний хэмжээ 2.9 тэрбум ам.доллар, импорт 3.6 тэрбум ам. доллар болж өссөн байна¹.

Өнөөгийн байдлаар Умард Солонгос экспортын бүтээгдэхүүнийхээ 66 хувийг Хятадад, 24 хувийг Өмнөд Солонгост, 1 хувийг Индонезид, 9 хувийг бусад улс орнуудад гаргаж буй аж². Экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд 41 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, 28 хувийг далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, 18 хувийг нэхмэл бүтээгдэхүүн, 13 хувийг электрон бараа эзэлдэг байна³.

1. Өмнөд Солонгосын Олон улсын худалдааны ассоциаци (КИТА)-“Стратегийн судалгаа” сэтгүүлийн 2014/1, № 65,83 дахь талаас дам ишлэв.

2. North Korea Trade-2012

Импортын хувьд 68 хувийг Хятадаас, 21 хувийг Өмнөд Солонгосоос, 4 хувийг Энэтхэгээс, 6 хувийг бусад улс орнуудаас авдаг аж. Хятадаас импортлож буй бараа бүтээгдэхүүний дийлэнхи хувийг газрын тос, хүнсний бүтээгдэхүүн эзэлдэг байна⁴.

Хятад улс болон Хойд Солонгосын тал хоёр улсын хооронд худалдаа эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэн тэлэх зорилгоор хоёр улсыг холбосон 3 км урт, 33 метрийн өргөнтэй гүүрийг Ялу голын дээгүүр барьж байна. Энэ гүүр нь 340 сая ам.долларын өртөгтэй бөгөөд Хятадын Ляонин мужийг хойд Солонгосын Синыйжу хоттой холбож байна. Гүүрийг ирэх оны 9 дүгээр сард ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна. Гүүрний хоёр талд хилийн шалган нэвтрүүлэх цэг байгуулах юм.

Хятад улс Хойд Солонгост хүнсний тусламжийг 3-4 сарын хугацаанд тогтмол илгээж, ажиллах хүч авч ажиллуулж байгаа нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой хүчин зүйлийн нэг болж байгаа билээ.

3. ОХУ, БНАСАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа

Энэ онд хоёр орны харилцааг батжуулж, шинэ шатанд гаргахад чиглэсэн олон чухал үйл явдал болж байгаагийн нэг нь ОХУ-ын төрийн Думаас Хойд Солонгосын нийт өрийн 90 хувь буюу 10.96 тэрбум ам.долларыг цайруулсныг албан ёсоор батламжилж,үлдсэн 1.09 тэрбум ам.долларыг Хойд Солонгос 20 жилийн турш сар бүр тэнцүү хэмжээгээр хувааж, Оросын Внешэкономбанкаар дамжуулан төлж дуусгахаар гэрээ байгуулжээ. Гэхдээ энэ төлбөр харьцангуй уян хатан байх аж. Хэрэв Хойд Солонгос сургууль цэцэрлэг барих болбол улсынхаа төсвөөс биш харин Оросын хөрөнгө оруулалт гэж нэрлээд өрнөөсөө зарцуулж, өрөө багасгахаар гэрээнд заасан байна¹. Үүний зэрэгцээ Оросын “Газпром” компани Хойд, Өмнөд Солонгосоор дамжуулан жилд 10 тэрбум куб метр байгалийн хийн хоолой татах,

3. <http://www.youmuri.co.jp>

4. Өмнөд Солонгосын Олон улсын худалдааны ассоциаци (КИТА)- “Стратегийн судалгаа” сэтгүүлийн 2014/1, №65, 83 дахь талаас дам ишлэв.

1. <http://www.assa.mn/content/17891.shtml>

*Зүүн Хойд Азид дөрвөн талт (3+1) хамтын ажиллагаа өрнүүлэн
хөгжүүлэх боломж арга зам*

Ази-Европыг холбосон авто болон төмөр замын мега төслийн яриа хэлэлцээр нааштайгаар ид өрнөж байна.

Түүнчлэн хоёр улсын Засгийн газар хоорондын Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны комисс энэ оны ээлжит хуралдаанаар хоёр улсын худалдааны харилцааг шинэ түвшинд гаргаж худалдааны нийт хэмжээг 2020 он гэхэд 1 тэрбум ам.долларт хүргэж, хоорондын төлбөр тооцоог рублиэр хийхээр тохиролцоонд хүрлээ. Энэ үеэр хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх, томоохон мега төслүүд хэрэгжүүлэх чиглэлээр олон гэрээ хэлэлцээрүүд байгуулагдлаа. Тухайлбал, гурван улсын тохиролцооны дагуу Солонгосын хойгийг Транссибирын төмөр замтай холбох, байгалийн хий болон эрчим хүчийг Хойд Солонгосын нутгаар дажуулан Өмнөдөд хүргэх, хоёр Солонгосын аж үйлдвэрийн “Кэсон” цогцолборт оросын компаниуд хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах, эдийн засгийн тусгай бүс байгуулах, хөрөнгө оруулалтыг хуулиар хамгаалах, визний хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлууд орж байна.

Түүнчлэн Раджин-Сонбон боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг өргөтгөж, теникийн шинэчлэлтэд зориулан хамтарсан хөрөнгө оруулалт хийх, Хойд Солонгосын уулын баяжуулах үйлдвэрт техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх “Победа “ төсөл, иргэний барилга байгууламжуудын эрчим хүчний хангамжийг сэргээн тоноглох төслүүдийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцсон байна².

Тун саяхан БНАСАУ-ын удирдлага дээрхи гэрээ хэлэлцээрүүдийг ажил хэрэг болгож Оросын хөрөнгө оруулагчид болон компаниудын ажилтнуудад виз олгох нөхцөлөө хөнгөлж, Оросын бизнесменүүд Хойд Солонгост байх хугацаандаа интернет, гар утас зэрэг орчин үеийн техник, технологи ашиглахыг зөвшөөрсөн шийдвэр гаргасан байна³. Түүнчлэн хоёр улсын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн дагуу ОХУ БНАСАУ-аас ажиллах хүч авч ажиллуулах явдал жил ирэх бүр өсөн нэмэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд Оросын Алс Дорнодын бүс нутаг, Хойд Солонгосын хил орчмын бүс нутгийн харилцан ашигтай худалдаа-

2. <http://www.rosbalt.ru/business/2014/03/28/1249740.html>

3. “Өдрийн сонин” 2014.06.066

эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа ч түргэн хурдацтай өрнөн хөгжиж байна.

Ийнхүү ЗХА-иар хязгаарлагдахгүй, дэлхийн хэмжээний их гүрнүүд болох хоёр хөрш маань ч энэ бүс нутагт тийм уялдуулан зохицуулсан бодлого, үйл ажиллагаа явуулах болов. Хоёр хөршийн энэхүү бодлого, үйл ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх нэн таатай хөрс суурь нэгэнт бий болсныг саяхан Шанхайд болсон The Fourth Summit of the Conference on International and Confidence Building Measures in Asia (CICA)-ын үеэр 2 хөршийн удирдагчидын уулзалт, энэ үеэр байгуулсан аварга том мега төслүүд илтгэн харууллаа.

Монгол улсын хувьд Зүүн Азийн Умард-Өмнөд хийгээд Дорнод-Өрнөдийн чиглэлийн зам тээвэр болон тээвэрлэлт, дамжуулах хоолой, эрчим хүч зэрэг дэд бүтцийн зангилаа болж, түүнийг уялдуулан зохицуулдаг штаб нь байрлах хамгийн тохиромжтой орон юм. Түүний бэлтгэл гэж үзэхээр Япон улсын хөрөнгө оруулалтаар Олон улсын зэрэглэлтэй томоохон нисэх онгоцны буудал тун удахгүй ашиглалтанд орно. Түүнийг дагаад олон улсын санхүү-бизнесийн төвүүд үүд хаалгаа нээхээр ид ажиллаж байна. Бид Зүүн хойд Азийн чөлөөт худалдааны нийгэмлэг (NEAFTA)-г байгуулж болох хувилбар, санал санаачлагуудыг ч анхааралтай ажиглаж байна. Цаашлаал Зүүн Азийн чөлөөт худалдааны олон улсын хэлэлцээрүүдийн “Noodle Bowl”-д хийгээд АПЕК-д нэгдэх сонирхол бий.

Монгол улс ийнхүү ЗХА-ийн олон талт хамтын ажиллагаанд нэгдэхэд Хятад, Орос, Умард Солонгосын уламжлалт найрсаг харилцаа онцгой ач холбогдолтой. 3+1-ийн харилцаа хамтын ажиллагаа, харилцан ойлголцол бэхжиж байх нь ЗХА-ийн энх тайван, аюулгүй байдал ихээхэн тустай юм.

БНСУ-Япон-АНУ гэсэн сайн харилцааны туйлуудын жишгээр бүс нутгийн олон улсын харилцаанд оролцогч улс гүрнүүд бүгд нэгэн ижил эрмэлзэлтэй болж, хамтын эрх ашгаа хамгаалж итгэлцэлийг бэхжүүлэхэд дөхөм үзүүлэх нэгэн хувилбар болох 3+1-ийн харилцааг бэхжүүлэх нь ЗХА-ийн аюулгүй байдалд эерэг хүчин зүйл болно гэж үзэж байна.

*Зүүн Хойд Азид дөрвөн талт (3+1) хамтын ажиллагаа өрнүүлэн
хөгжүүлэх боломж арга зам*

3+1-ийн харилцааны гол тулгуур нь өнөөгийн нөхцөлд ашиг сонирхлын тэнцвэрт байдлаа олсон ЗХА төдийгүй, олон улсын харилцаанд томоохон нөлөө бүхий Хятад, ОХУ байх нь мэдээж. Цаашдаа 3+1 дээр нэмж Монгол, ОХУ, БНХАУ-тай аль алинтай таатай харилцаа бүхий бүс нутагтаа томоохон үүрэгтэй БНСУ-ыг татан оролцуулж, бүс нутгийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээр эхлүүлэх боломжтой.

ЗХА дахь хамтын ажиллагааг шууд цэрэг-улс төрийн түвшнээс бус юуны өмнө худалдаа, эдийн засгийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхээс эхлэх нь илүү ач холбогдолтой мэт санагдаж байна.

БНАСАУ ч гэсэн сүүлийн үед хөрш 2 оронтой худалдаа эдийн засгийн харилцаагаа өргөтгөх, хөрөнгө оруулалтыг татах чиглэлд олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, бүсийн орнуудтайгаа худалдаа, эдийн засгийн харилцаагаа өргөтгөх, олон улсын ачаа тээврийн салбарт хамтран ажиллах болон хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх боломж олгох үүднээс төмөр замын салбарын тухай хуулиндаа өөрчлөлт орууллаа. Хуулийн өөрчлөлтүүд нь гэрээ контракт байгуулах дүрэм журмууд, хохирол, тарифын хязгаарлалтуудыг багасгах болон маргаантай асуудлуудыг шийдвэрлэх зэрэгтэй холбоотой байна. Энэхүү өөрчлөлтүүд нь Умард Солонгосын зүгээс хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалахтай холбоотой амлалтууд болон тэдгээрийн ашиг сонирхолуудыг хангахад чиглэгдсэн баримт бичиг болж байгаараа чухал ач холбогдолтой юм. Нөгөө талаар энэ нь Орос, Хятадын хил орчмын Наджин боомтыг бүс нутгийн тээврийн ложистик зангилаа болгоход оршиж байна.

БНАСАУ сүүлийн үед ЗХА-ийн худалдааны яармаг, Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоо Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоо (The Association of North East Asia Regional Governments) зэрэг бүсийн олон талт хамтын ажиллагааны байгууллагуудтай эдийн засаг, гадаад худалдаа, боловсрол соёлын харилцаа, байгаль орчин, гамшгаас сэргийлэх, хилийн хамтын ажиллагаа, шинжлэх ухаан, технологи далай загасны аж ахуй, аялал жуулчлал, эрдэс баялаг боловсруулалт, зохицуулалт, эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт, хүүхэд эмэгтэйчүүд зэрэг төрөл бүрийн салбарт хамтын төслүүд хэрэгжүүлж байна.

Дүгнэлт

Өнөөдөр ямар ч улс бусад бүс нутаг, улс орнуудтай улам ойртож харилцахгүйгээр үндэсний өрсөлдөх чадвар, бүс нутгийн хөгжлийг дэмжин тэтгэж чадахгүй. Дэлхийн шинэ тогтолцоо “зөрчил мөргөлдөөнөөс найрамдал, хамтын ажиллагаа” руу шилжиж байна.

Дэлхийн эдийн засгийн шинэ зааг – Зүүн Хойд Азийн Бүсийн нэгдэлд Хятад, Орос, Монгол, БНАСАУ уламжлалт найрсаг харилцаан дээр тулгуурласан эдийн засаг, байгаль орчин, аялал жуулчлал зэрэг олон салбарын идэвхтэй харилцаа, хамтын ажиллагаа нь 3+1 харилцаа өрнөн хөгжих нэн таатай нөхцлийг бүрдүүлж байна.